



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 17/07

Улаанбаатар хот

“Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ын эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн зургаадугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,275,413,227.30 (нэг тэрбум хоёр зуун далан таван сая дөрвөн зуун арван гурван мянга хоёр зуун хорин долоон төгрөг гучин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК (Ж.Энхжаргалан)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй үндсэн хөрөнгөөс 1 нэр төрлийн 292,934,000 (хоёр зуун ерэн хоёр сая есөн зуун гучин дөрвөн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 1 нэр төрлийн 982,479,227.30 (есөн зуун наян хоёр сая дөрвөн зуун далан есөн мянга хоёр зуун хорин долон төгрөг гучин мөнгө) төгрөгийн хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК (Ж.Энхжаргалан)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В.Оюумаа* В.ОЮУМАА



1150500786

